




МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вирус
(COVID - 19) халдварын тархалтаас урьдчилан
сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний
үзүүлсэн нөлөөлөл

2021 оны 3-р сарын тандалт судалгаа

ОРШИЛ

“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (COVID - 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл”-ийн 2021 оны 3-р сарын тандалт судалгааны дүнг танилцуулъя.

“Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөлөл”-ийн 2021 оны 3-р сарын тандалт судалгаанд үйл ажиллагаа явуулж байгаа 2431 аж ахуйн нэгж хамрагдсан.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ,
салбарын ангиллаар, дүнд эзлэх хувиар, 2021 оны эхний улирлын байдлаар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	91 685	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	36 038	39.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	9 079	9.9
Барилга	7 271	7.9
Боловсруулах үйлдвэрлэл	5 726	6.2
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5 540	6.0
Боловсрол	4 590	5.0
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3 417	3.7
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	3 116	3.4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2 753	3.0
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	2 256	2.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2 210	2.4
Мэдээлэл, холбоо	2 111	2.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1 955	2.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1 626	1.8
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1 199	1.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1 189	1.3
Уул уурхай, олборлолт	1 118	1.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	266	0.3
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	189	0.2
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	36	0.0

ҮСХ-ноос 2021 оны 3-р сарын судалгааны мэдээллийг 4-р сарын 10-наас 21-ний өдрүүдэд цуглуулав. ҮСХ-ноос цар тахлын халдварын тархалт ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа, тэдний орлого, үйлдвэрлэлд гарсан өөрчлөлт, ажлын байраа хадгалж буй байдал, ялангуяа Засгийн газар, Улсын онцгой комиссоос тухай бүр гаргаж буй шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрхэн удирдаж, төлөвлөж буйг дараах үе шатаар тандан судалж байна. Үүнд:

- Нэг дэх шатны судалгааг 2020 оны 5-р сарын 6-наас 20-ны өдрүүдэд,
- II шатны судалгааг 7-р сарын 27-ноос 8-р сарын 10-ны өдрүүдэд,
- III дахь шатны судалгааг 12-р сарын 15-наас 28-ны өдрүүдэд
- 2021 оноос судалгааны мэдээллийг сар бүр цуглуулан авч байна.

Манай улс 2021 оны 2-р сарын 23-ны өдрөөс вакцинжуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-ээс “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн.

Энэ оны 3-р сар гарсаар эхний 10 хоногийн төгсгөлөөс эхлэн халдварын тархалт ихээхэн нэмэгдсэн. Тухайлбал, 3-р сарын 7-ны өдөр корона вируст халдварын 109 тохиолдол батлагдсан нь цар тахлын халдвар дотоодод тархсанаас хойших хугацаанд 100-гаас давсан анхны тохиолдол болсон юм. 3-р сард цар тахлын 5849 шинэ тохиолдол батлагдсан нь өмнөх саруудтай харьцуулахад тархалтын хамрах хүрээ, эрсдэл эрс нэмэгдсэн юм.

Энэ удаагийн судалгааны мэдээллийг дээрх хугацаанд цар тахал ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг 2020 онд хийсэн гурван шатны судалгаа болон 2021 оны 1, 2-р сард хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулав.

Монгол улсад Корона вируст (Covid 19) халдвар бүртгэгдсэн анхны тохиолдлоос эхлэн Засгийн газраас халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг арга хэмжээг зохион байгуулж байна. Монгол Улсын Засгийн газраас :

- 2021 оны 1-р сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор 1-р сарын 11-нийг дуустал,
- 2021 оны 2-р сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 2-р сарын 11-нээс 23-ны өдрийг хүртэл хэсэгчилсэн байдлаар нийслэл Улаанбаатар хотод “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлэх шийдвэрийг гаргасан.


Ийнхүү 2-р сарын 23-наас эхлэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэглэл буурч “Өндөржүүлсэн байдлын зэрэг”-т шилжсэн. Хүн амыг вакцинжуулах ажил мөн энэ цаг хугацаатай зэрэгцэн эхэлсэн.

ЗУРАГ 2. ХАТУУ ХӨЛ ХОРИО ТОГТООСОН ҮЕ, хугацаагаар



Судалгаанд хамрагдсан нийт аж ахуйн нэгжийн 44.8% нь 2021 оны 3-р сард үйл ажиллагаа хэвийн явагдаж байна, 55.2% нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ. Өмнөх сард явагдсан тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААН-ийн эзлэх хувь 1.2 пунктээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, судалгаа явагдсан хугацаагаар



Корона вируст халдварын зөөвөрлөгдсөн тохиолдол бүртгэгдэж, анх удаа хөл хорио тавигдаж эхэлсэн үетэй харьцуулахад үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа ААН-ийн эзлэх хувь 2021 оны 3-р сард 1.5 пунктээр буурсан байна.

Энэ нь хатуу хөл хорионы дэглэм суларсантай холбогдуулан ААН-ийн үйл ажиллагаанд бага зэргийн сэргэлт гарсныг харуулж байна. Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг аврах 10 их наяд төгрөгийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, ААН-үүдэд жилийн 3 хувийн хүүтэй эргэлтийн хөрөнгийн зээл олгох зэрэг ажлыг эхлүүлсэн нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг идэвхжүүлэх хөшүүрэг болсон байж болох талтай.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа ААН-ийн 20.7% нь улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд байна.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа 1089 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар (Хүснэгт 2) харуулбал:

- 343 (31.5%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 155 (14.2%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 90 (8.3%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ,
- 71 (6.5%) нь хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа,
- 59 (5.4%) нь санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа,
- 52 (4.8%) нь барилга,
- 52 (4.8%) нь боловсрол,
- 42 (3.9%) нь тээвэр, агуулах,
- 225 (20.7%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, цахилгаан, хий, агааржуулалт, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, олборлолт, мэдээлэл холбоо, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, урлаг, үзвэр, тоглоом, үйлчилгээний бусад, үс хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх, аялал жуулчлалын зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.

Бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг 598 ААН-ийн 42.6 хувь нь “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна” гэж хариулжээ. Түүнчлэн:

- Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 68 ААН-ийн 91.2 хувь,
- Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг 218 ААН-ийн 76.1 хувь,

- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг 158 ААН-ийн 74.1 хувь,
- Боловсролын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 162 ААН-ийн 67.9 хувь,
- Тээвэр, агуулахын үйл ажиллагаа эрхэлдэг 126 ААН-ийн 66.7 хувь,
- Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ эрхэлдэг 257 ААН-ийн 65.0 хувь,
- Үл хөдлөх үйл ажиллагаа эрхэлдэг 75 ААН-ийн 62.7 хувь,
- Урлаг, үзвэр тоглоомын үйл ажиллагаа эрхэлдэг 24 ААН-ийн 62.5 хувь нь үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байна гэсэн хариултыг өгсөн байна.


ХҮСНЭГТ 2. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХЭВИЙН БУС АЖ АХУЙН НЭГЖҮҮД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар, дүнд эзлэх хувиар

Салбар	Үйл ажиллагаа нь хэвийн бус аж ахуйн нэгж					
	2020 I шат	2020 II шат	2020 III шат	2021 - I	2021 - II	2021 - III
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	5.0	5.6	5.8	6.3	7.9	8.7
Уул уурхай, олборлолт	1.2	1.3	1.3	2.0	2.0	2.1
Боловсруулах үйлдвэрлэл	8.2	10.4	8.9	11.4	10.9	10.4
Цахилгаан, хий, агааржуулалт	0.5	0.4	0.1	0.3	0.4	0.1
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	0.2	0.2	0.1	0.0	0.0	0.1
Барилга	8.1	7.1	10.5	11.3	11.9	12.4
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	20.8	18.0	19.2	19.3	17.7	19.0
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	5.4	6.2	5.5	5.7	5.2	6.3
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	12.1	10.1	11.1	12.7	13.6	12.4
Мэдээлэл, холбоо	1.4	1.1	0.9	0.8	0.7	0.9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.2	2.9	3.7	3.4	3.3	2.8
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3.0	3.8	4.2	4.0	4.4	3.5
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	2.9	3.2	2.5	3.9	3.2	3.3
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.3	1.0	1.4	1.7	1.0	1.0
Аялал жуулчлал	5.1	5.8	4.2	4.1	4.4	4.6
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн даатгал	0.2	0.3	-	-	-	-
Боловсрол	12.2	10.0	11.1	9.0	9.7	8.2
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	3.0	3.1	2.6	2.2	2.0	2.8
Урлаг, үзвэр, тоглоом	2.3	2.0	2.4	1.5	1.2	1.1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	4.8	7.4	4.5	0.5	0.4	0.4

Судалгаанд “Үйл ажиллагаа хэвийн явагдахгүй байгаа” гэсэн хариулт өгсөн 1342 аж ахуйн нэгжийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулбал:

- 255 (19.0%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 167 (12.4%) нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 166 (12.4%) нь барилгын салбар,
- 140 (10.4%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 117 (8.7%) нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар,
- 110 (8.2%) нь боловсролын салбар
- 387 (28.8%) нь тээвэр, агуулах, аялал жуулчлал, үл хөдлөх хөрөнгө, мэргэжлийн шинжлэх ухаан болон техник, санхүүгийн болон даатгал, хүний эрүүл мэнд, нийгмийн халамж, уул уурхай, олборлолт, урлаг, үзвэр, тоглоом, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, мэдээлэл холбоо, үйлчилгээний бүсад, цахилгаан, хий, агааржуулалт, ус хангамж: сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх зэрэг салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байна.

ЗУРАГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВАГДАХГҮЙ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, дүнд эзлэх хувиар салбараар, 2021 оны 3-р сард



СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ

Монгол Улсын Засгийн газраас “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэн шийдвэртэй холбогдуулан “Үйл ажиллагаа нь хэвийн бус” гэж хариулсан 1342 ААН-ийн 909 (67.7%) нь үйл ажиллагаа хүндэрсэн гэж хариулжээ.

Энэ нь өмнөх сард явагдсан судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа ААН-үүдийн хувьд санхүүгийн хүндрэл илүү гүнзгийрсэн байна.

ХҮСНЭГТ 3. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар, 2020 онд явагдсан 3 шатны судалгааны үр дүнгээр

№	2020 I шат		2020 II шат		2020 III шат	
	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь
1	Санхүүгийн байдал хүндэрсэн	48.2	Санхүүгийн байдал хүндэрсэн	43.8	Санхүүгийн байдал хүндэрсэн	55.5
2	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	44.9	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	37.2	Хатуу хөл хорио дуустал үйл ажиллагаагаа түр зогсоосон	47.2
3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	27.8	Корона вирусээс (Covid-19) урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөл хорио тавигдтал үйл ажиллагаагаа түр зогсоосон	36.3	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	41.4
4	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	24.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	22.8	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	31.7
5	Зээл, зээлийн хүүг төлөхөд хүндрэлтэй болсон	23.8	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	20	Зээл, зээлийн хүүг төлөхөд хүндрэлтэй болсон	27.2

2021 оны 3-р сарын судалгаанд (Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаа) үйл ажиллагаа нь хүндэрсэн гэж хариулсан ААН-ийн дийлэнх нь буюу 70.3% нь “Санхүүгийн байдал хүндэрсэн” гэсэн хариултыг өгсөн байна. Энэ нь өмнөх сард явуулсан судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.8 пунктээр, 1-р сард явуулсан судалгааны үр дүнгээс 2.2 пунктээр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 4. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, хамгийн их давтагдсан 5 шалтгаанаар, 2021 оны 1-3 сарын судалгааны үр дүнгээр

№	2021 – I		2021 – II		2021 – III	
	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь	Шалтгаан	Дүнд эзлэх хувь
1	Санхүүгийн байдал хүндэрсэн	72.5	Санхүүгийн байдал хүндэрсэн	71.1	Санхүүгийн байдал хүндэрсэн	70.3
2	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	58.7	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	60.5	Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	62.2
3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	44.3	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	41.6	Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	40.6
4	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	37.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	33.1	Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	36.0
5	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	34.4	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	32.2	ААН-ийн орлогын албан татвар, бусад татвар хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	33.3

2020 онд явагдсан 3 шатны судалгаанд “Санхүүгийн байдал хүндэрсэн”, “Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан” гэсэн шалтгаануудыг судалгаанд хамрагдсан ААН-ийн олонх нь дурдаж байсан бол энэ оны судалгаанд мөн дээрх байдал хэвээр хадгалагдаж байна. Энэ нь “Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж, хатуу хөл хорио тогтоосон хугацаанд ААН-ийн санхүүгийн байдал хугацаа өнгөрөх тусам муудсаар байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 5. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, БЭРХШЭЭЛ, шалтгаанаар


Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	ААН-ийн дүнд эзлэх хувь
Санхүүгийн байдал хүндэрсэн	639	70.3
Үйлчлүүлэгчийн тоо эрс буурсан	565	62.2
Ажиллагчдынхаа цалинг олгох, НДШ-ийг төлөхөд хүндрэлтэй болсон	369	40.6
Үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ эрс буурсан	327	36.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, хураамжийг төлөхөд хүндрэлтэй болсон	303	33.3
Түүхий эд материал, барааны эргэлт удааширч, хомсдол үүссэн	284	31.2
Зээл, зээлийн хүү төлөхөд хүндрэлтэй болсон	268	29.5
Түрээсийн төлбөрөө төлөхөд хүндрэлтэй болсон	192	21.1
Төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийгдээгүй, хойшлогдсон	157	17.3
Ажиллагчдын тоог бууруулсан	135	14.9
Бусад төлбөр төлөхөд хүндрэлтэй болсон (ус, цахилгаан, дулаан гэх мэт)	122	13.4
Бусад	119	13.1

Тайлбар: Хариулт нь олон сонголттой бөгөөд олон давтагдсанаар нь эрэмбэлсэн.

2. ОРЛОГОД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан гэж хариулсан 909 ААН-ийн дийлэнх нь буюу 724 (79.6%) нь Монгол Улсын Засгийн газраас “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан 3-р сард өмнөх сараас “Орлого буурсан” гэж хариулсан бол 185 (20.4%) нь өмнөх сараас орлого буураагүй гэж хариулсан байна. Орлого буурсан ААН-ийн эзлэх хувь өмнөх сарын судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.6 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 4. ОРЛОГО БУУРСАН ААН-ИЙН НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ,
орлогын бүлгээр, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар



2021 оны 3-р сард үйл ажиллагаа нь хүндэрч “Орлого буурсан” 724 ААН-ийг бүлэглэж авч үзвэл, орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН 61.5 хувь, 41-50 хувиар буурсан ААН 11.0 хувь, 31-40 хувиар буурсан ААН 10.5 хувь, 21-30 хувиар буурсан ААН 8.3 хувь, 11-20 хувиар буурсан ААН 5.9 хувь, 10 хүртэл хувиар буурсан ААН 2.8 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх сард явуулсан судалгааны үр дүнтэй харьцуулахад 50-иас дээш хувиар орлого буурсан ААН-ийн эзлэх хувь 0.4 пунктээр, орлого нь 41-50 хувиар буурсан ААН-ийнх 0.4 пунктээр, орлого нь 31-40 хувиар буурсан ААН-ийнх 0.2 пунктээр, орлого нь 10 хүртэл хувиар буурсан ААН-ийнх 0.2 пунктээр тус тус нэмэгдсэн бол орлого нь 11-20 хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 0.3 пунктээр буурсан байна.

2020 оны 3-р сард манай улсад анх Корона вируст халдвар бүртгэгдэж эхэлж байх үед судалгаанд хамрагдсан ААН-ийн 43.7 хувийнх нь орлого 50-иас дээш хувиар буурч байсан бол энэ байдал хугацаа өнгөрөх тусам улам гүнзгийрсэн байдал ажиглагдаж байна.

2021 оны 3-р сард орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 2020 оны эхний шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад 17.8 пунктээр өсжээ.

Засгийн газраас “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлснээс шалтгаалан 2021 оны 3-р сард орлого буурсан 724 аж ахуйн нэгжийг эдийн засгийн салбараар харуулбал,

- 172 (23.8%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ,
- 108 (14.9%) нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 84 (11.6%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 70 (9.7%) нь боловсролын салбар,
- 52 (7.2%) нь тээвэр, агуулахын салбар,
- 44 (6.1%) нь барилгын салбар,

- 31 (4.3%) нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн салбар,
- Үлдсэн 163 (22.5%) нь санхүүгийн болон даатгалын, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн, аялал жуулчлал, уул уурхай, олборлолтын, урлаг, үзвэр, тоглоом, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, холбоо, үйлчилгээний бусад салбаруудад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд байна.


ХҮСНЭГТ 6. ӨМНӨХ САРААС ОРЛОГО БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, дүнд эзлэх хувиар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	728	100.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	172	23.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	108	14.9
Боловсруулах үйлдвэрлэл	84	11.6
Боловсрол	70	9.7
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	52	7.2
Барилга	44	6.1
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	31	4.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	29	4.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	25	3.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	25	3.5
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	24	3.3
Уул уурхай, олборлолт	17	2.3
Аялал жуулчлал	16	2.2
Урлаг, үзвэр, тоглоом	9	1.2
Мэдээлэл, холбоо	8	1.1
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	6	0.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3	0.4
Ус хангамж: Сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1	0.1

3. ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

Засгийн газраас “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлсэнтэй холбоотойгоор 2021 оны 3-р сард үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан 909 ААН-ийн 674 буюу 74.1 хувийнх нь үйлдвэрлэл өмнөх сараас буурсан бол 235 ААН буюу 25.9 хувь нь үйлдвэрлэл буураагүй гэсэн хариулт өгчээ.

ЗУРАГ 5. ҮЙЛДВЭРЛЭЛ БУУРСАН АЖ АХУЙН НЭГЖИЙН НИЙТ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ,
бүлгээр, өмнөх шатны судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар



Үйлдвэрлэл нь 2021 оны 3-р сард өмнөх сараас буурсан нийт ААН-ийн дийлэнх буюу 65.0 хувь нь үйлдвэрлэл 50-иас дээш хувиар, 10.2 хувь нь 41-50 хувиар, 10.5 хувь нь 31-40 хувиар, 7.3 хувь нь 21-30 хувиар, 4.9 хувь нь 11-20 хувиар, 2.1 хувь нь 10 хүртэл хувиар үйлдвэрлэл буурсан гэж тус тус хариулсан байна.


Үйлдвэрлэлийн бууралтын хувийг 2020 оны 3 дахь шатны судалгааны үр дүнтэй харьцуулахад үйлдвэрлэл нь 50-иас дээш хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 2.6 пунктээр, үйлдвэрлэл нь 31-40 хувиар буурсан ААН-ийнх 0.4 пунктээр, үйлдвэрлэл нь 11-20 хувиар буурсан ААН-ийнх 2.0 пунктээр тус тус өссөн бол үйлдвэрлэл нь үйлдвэрлэл нь 21-30 хувиар буурсан ААН-ийнх 1.4 пунктээр, үйлдвэрлэл нь 41-50 хувиар буурсан ААН-ийнх 3.5 пунктээр тус тус буурсан байна.

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирч үйлдвэрлэл, орлого нь 50-иас дээш хувиар буурсан ААН-үүдийн эзлэх хувь хатуу хөл хорио тогтоож эхэлсэн үеэс хойш тогтмол 60 хувиас давсан байна. Хэдийгээр 3-р сард зэрэглэл бууруулж, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн ч үйлдвэрлэлийн бууралт илүү нэмэгдэж өмнөх сартай харьцуулахад үйлдвэрлэл нь 50-иас дээш хувиар буурсан ААН-ийн эзлэх хувь 2.6 пунктээр өсжээ.

4. ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан 909 ААН-ийн 322 (35.4%) нь ажиллагчдынхаа цалинг 3-р сард бууруулсан бол 587 (64.6%) нь цалин бууруулах арга хэмжээ аваагүй байна.

ЗУРАГ 6. ЦАЛИН БУУРУУЛСАН ААН, бүлгээр, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар, дүнд эзлэх хувь



Цалингаа бууруулах арга хэмжээ авсан нийт ААН-ийн олонх буюу 51.9 хувь нь 50-иас дээш хувиар цалингаа бууруулсан бол, 8.4 хувь нь 41-50 хувиар, 5.3 хувь нь 31-40 хувиар, 5.6 хувь нь 21-30

хувиар, 5.6 хувь нь 11-20 хувиар, 2.5 хувь нь 10 хүртэл хувиар цалингаа бууруулсан байна. Харин 20.8 хувь нь ажиллагчдадаа цалингаа хийснээр нь олгосон байна.

3-р сард цалингаа 50-иас дээш хувиар бууруулсан ААН-ийн эзлэх хувь өмнөх сараас 13.2 пунктээр нэмэгдсэн бол цалингаа ажилласан цагаар нь буюу хийснээр нь олгосон ААН-ийнх 22.2 пунктээр бүүрчээ. Энэ нь ААН-д учирч буй хүндрэл, бэрхшээл гүнзгийрч, нөөц боломж суларч байгааг харуулж байна.

5. АЖИЛЛАГЧДАДАА ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ЗАЙНААС АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ

ХҮСНЭГТ 7. ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОЖ, ЗАЙНААС АЖИЛЛАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙДАЛ, өмнөх судалгаануудын үр дүнтэй харьцуулснаар

	Дүнд эзлэх хувь					
	2020 I шат	2020 II шат	2020 III шат	2021 – I	2021 – II	2021 – III
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлсэн	33.9	37.3	41.4	39.0	18.4	34.8
Цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломж бүрдүүлээгүй	66.1	62.7	58.6	61.0	81.6	65.2

Засгийн газраас Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд судалгаанд хамрагдаж үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан нийт аж ахуйн нэгжийн 34.8% нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн бол 65.2% нь буюу дийлэнх нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлээгүй байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд буюу өмнөх сартай харьцуулахад цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн ААН-ийн эзлэх хувь 16.4 пунктээр нэмэгдсэн бол 1-р сарын судалгааны үр дүнтэй харьцуулахад 4.2 пунктээр буурсан байна. Энэ нь Корона вирус халдвар манай улсад анх бүртгэгдэж эхэлсэн үе буюу 2020 оны I шатны судалгааны үр дүнтэй ойрцолцоо түвшинд байна.

Ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, зайнаас ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн ААН-үүдээс энэ арга хэмжээгээ одоо үргэлжлүүлж буй эсэхийг асуухад 78.2% нь тийм, 21.8% нь үгүй гэж хариулсан байна.


Корона вирусний тархалт дэлхий нийтээр эрчимтэй явагдаж, эхний давлагаа хүчтэй өрнөж байх үед судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 37.3 хувь нь ажиллагчдадаа цалинтай чөлөө олгож, гэрээсээ ажиллах нөхцөлийг бүрдүүлж байсан бол 2021 оны 3-р сард судалгаанд хамрагдаж, үйл ажиллагаа нь хүндэрсэн ААН-ийн 78.2 хувь нь тус арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлж байна.

6. ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН НӨЛӨӨ

ЗУРАГ 7. ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Үйл ажиллагаанд нь хүндрэл учирсан нийт ААН-ийн олонх буюу 39.3% нь Өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан “Хэсэгчлэн үйл ажиллагаагаа явуулсан” бол 58.5% нь “Тэг зогсолт” хийсэн байна. Харин 2.2 хувь нь үйл ажиллагаа нь хүндэрсэн ч үргэлжлүүлэн хэвийн явуулсан байна.


Энэ нь өмнөх сард явагдсан тандалт судалгааны үр дүнтэй харьцуулахад хэсэгчлэн үйл ажиллагаа явуулсан ААН-ийн эзлэх хувь 31.2 пунктээр нэмэгдсэн байна. Энэ нь 2-р сард тавигдсан хатуу хөл хорионы зэрэглэл буурсантай холбоотой юм.



“Тэг зогсолт хийсэн” ААН-ийн эзлэх хувь өмнөх сараас 33.0 пунктээр буурсан бол хэвийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлсэн ААН-ийнх 1.9 пунктээр нэмэгдсэн байна.


7. АЖ АХУЙН НЭГЖИЙН АЖИЛЛАГЧДЫН ТОО

ЗУРАГ 8. ААН-ИЙН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР, ХУВИАР



Судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх буюу 1745 (71.8%) нь 1-9 ажиллагчидтай, 331 (13.6%) нь 10-19 ажиллагчидтай, 170 (7.0%) нь 20-49 ажиллагчидтай, 185 (7.6%) нь 50-иас дээш тооны ажиллагчидтай ААН-үүд байна.

ЗУРАГ 9. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОСОН ААН



Судалгаанд хамрагдсан нийт ААНБ-ын 234 (9.6%) нь Засгийн газраас Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд ажиллагчдаа цомхотгох арга хэмжээ авсан бол 2197 (90.4%) нь цомхотгол хийгээгүй байна.

Үүнээс харахад судалгаанд хамрагдсан ААН-ийн дийлэнх нь ажиллагчдаа цаашид цомхотгохгүйгээр ажиллуулах хүсэл эрмэлзэлтэй байгаа байдал ажиглагдаж байна.

ХҮСНЭГТ 8. ЦОМХОТГОЛ ХИЙСЭН ААН,
цомхотгосон ажиллагчдын тооны бүлгээр

	2021 - I		2021 - II		2021 - III	
	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь	ААН-ийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд	286	100.0	208	100.0	234	100.0
1-9 ажиллагч	252	88.1	182	87.5	217	92.7
10-19 ажиллагч	15	5.2	17	8.2	9	3.8
20-29 ажиллагч	10	3.5	2	1.0	3	1.3
30-39 ажиллагч	5	1.7	4	1.9	3	1.3
40-өөс дээш ажиллагч	4	1.4	3	1.4	2	0.9

Ажиллагчдаа цомхотгосон 234 ААН-ийг цомхотгосон ажиллагчдын тооны бүлгээр задалж авч үзвэл, дийлэнх буюу 1-9 хүртэл ажиллагчдаа цомхотгосон 217 ААН буюу 92.7 хувь, 10-19 хүртэл ажиллагчдаа цомхотгосон 9 ААН буюу 3.8 хувь, 20-29 ажиллагчдаа цомхотгосон 3 ААН буюу 1.3 хувь, 30-39 ажиллагчдаа цомхотгосон 3 ААН буюу 1.3 хувь, 40-өөс дээш тооны ажиллагчдаа цомхотгосон 2 ААН буюу 0.9 хувийг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 9. АЖИЛЛАГЧДАА ЦОМХОТГОХГҮЙ БАЙХ
БОЛОМЖТОЙ ХУГАЦАА, бүлгээр

	2021 - I	2021 - II	2021 - III
	Дүнд эзлэх хувь		
Бүгд	100.0	100.0	100.0
3 хүртэлх сар	13.2	14.1	11.7
3 – 6 сар	6.5	6.9	6.1
6 – 12 сар	3.2	2.6	2.3
Цомхотгол хийхгүй	43.2	45.2	42.9
Тодорхойгүй	33.9	31.2	37.0

Цаашид ямар хугацаанд ажиллагчдаа цомхотгохгүй байх боломжтой эсэхийг тодруулан асуухад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн олонх нь буюу 42.9% нь цомхотгол хийхгүй гэж хариулсан бол 37.0% нь тодорхойгүй, 11.7% нь 3 хүртэл сарын хугацаанд цомхотгол хийхгүй, 6.1% нь 3-6 сар хүртэлх хугацаанд цомхотгол хийхгүй, хамгийн бага буюу 2.3% нь 6-12 сар хүртэлх хугацаанд цомхотгол хийхгүй байх боломжтой гэж хариулсан байна.

Энэ нь өмнөх сард явуулсан судалгааны үр дүнтэй харьцуулахад “Цомхотгол хийхгүй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 2.3 пунктээр буурсан бол “Тодорхойгүй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 5.8 пунктээр нэмэгдсэн байна.

8. АЖ АХУЙН НЭГЖИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Монгол Улсын Засгийн газраас дахин “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлбэл ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар тодруулахад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн дийлэнх буюу 1500 (61.7%) нь маш их сөрөг нөлөөтэй, 645 (26.5%) нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй, 203 (8.4%) нь бага зэрэг сөрөг нөлөөтэй, 83 (3.4%) нь ямар нэг нөлөө үзүүлэхгүй гэж хариулсан байна.

ХҮСНЭГТ 10. ХАТУУ ХӨЛ ХОРИОГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХЭД ААН-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ


Энэ нь өмнөх сард явагдсан судалгааны үр дүнтэй харьцуулахад “Маш их сөрөг нөлөөтэй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 4.4 пунктээр өссөн бол “Дунд зэрэг сөрөг нөлөөтэй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 0.2 пунктээр, “Бага зэрэг сөрөг нөлөөтэй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 1.6 пунктээр, “Ямар нэг нөлөө үзүүлэхгүй” гэж хариулсан ААН-ийн эзлэх хувь 2.7 пунктээр тус тус буурсан байна.

	2021 - I	2021 - II	2021 - III
	Дунд эзлэх хувь		
Бүгд	100.0	100.0	100.0
Маш их сөрөг нөлөөтэй	56.1	57.3	61.7
Дунд зэрэг сөрөг нөлөөтэй	26.9	26.7	26.5
Бага зэрэг сөрөг нөлөөтэй	12.1	10.0	8.4
Ямар нэг нөлөө үзүүлэхгүй	4.9	6.1	3.4

9. ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА

Судалгаанд хамрагдсан 2431 ААН-ээс цаашид ямар хугацаанд үйл ажиллагаагаа хэвийн явуулах талаарх төсөөллийг асуухад, судалгаанд хамрагдсан нийт ААН-ийн 642 (26.4%) нь 3 сар хүртэл, 362 (14.9%) нь 3-6 сар хүртэл, 203 (8.4%) нь 6-12 сар хүртэл, 162 (6.7%) нь 1 жилээс дээш хугацаа шаардагдана гэж хариулсан байна. Харин 725 (29.8%) нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж эхлэх хугацаа тодорхойгүй гэж хариулсан бол 337 (13.9%) нь хэвийн ажиллаж байгаа гэсэн хариултыг өгсөн байна.

ЗУРАГ 10 . ААН-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭВИЙН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ ХУГАЦАА,
дүнд эзлэх хувиар



10. ААН-ЭЭС ӨГСӨН ЗАСГИЙН ГАЗРААС ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Судалгаанд хамрагдсан ААН-ийн хувьд төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаагаа сэргээхэд гарах асуудлуудыг төрийн бодлогоор шуурхай шийдэхэд дэмжлэг үзүүлэх - 1342

- Зээл авах боломжийг бий болгох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх – 1392
- Эрсдэл, гамшгийн үед ААН-ийн үйл ажиллагаа эдийн засагт учирч болох болзошгүй аюулаас сэргийлэх, даван туулах стратеги, бодлогыг боловсруулах – 1087
- Бусад – 141

Бусад шалтгаантай ААН-ийн саналыг олон давтагдсан байдлаар нь эрэмбэлж авч үзвэл:

- Зээл авахад тулгарч буй хүндрэлийг багасгах (барьцаа хөрөнгө, өндөр хүү, зээлийн бусад шаардлага),
- Нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах, хөнгөлөх,
- Хөл хорио аль болох тогтоохгүй байх
- Вакцинжуулалтыг эрс нэмэгдүүлэх
- Хил нээх зэрэг саналуудыг ААН-үүд хамгийн их өгсөн байна.

ДҮГНЭЛТ

Засгийн газраас Корона вируст (Covid 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний нөлөөгөөр судалгаанд хамрагдсан 2431 аж ахуйн нэгжийн 55.2% буюу олонх нь хэвийн явагдахгүй байна гэсэн хариулт өгчээ.

Үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа нийт аж ахуйн нэгжийг салбараар авч үзвэл, дараах салбарууд хамгийн их өртсөн байна. Үүнд:

- 19.0% нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбар,
- 12.4% нь зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар,
- 12.4% нь барилгын салбар,
- 10.4% нь боловсруулах үйлдвэрлэлийн салбар,
- 8.7% нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур,
- 8.2% нь боловсрол

Монгол Улсын Засгийн газраас Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн шийдвэртэй холбогдуулан “Үйл ажиллагаа нь хэвийн бус” гэж хариулсан 1342 ААН-ийн 909 (67.7%) нь үйл ажиллагаа нь хүндэрсэн гэсэн хариултыг өгсөн байна.

Өмнөх сарын сүүл боон 3-р сараас эхлэн вакцинжуулалтын ажил эхэлсэн хэдий ч Корона вируст халдварын тархалт огцом нэмэгдсэн бөгөөд энэ нь хатуу хөл хорионы зэрэглэлийг бууруулсантай шууд холбоотой байна.

Судалгаанд хамрагдсан ААН-үүдийн орлого болон үйлдвэрлэл өмнөх сарынхтай ижлээр буурч байгаа байдал нь хугацаа өнгөрөх тусам илүү гүнзгийрч байгаа бөгөөд энэ нь 50-иас дээш хувиар орлого болон үйлдвэрлэл нь буурсан ААН-ийн эзлэх хувь тогтмол 60 хувиас давснаар баталгаажиж байгаа юм.

Цаашид Засгийн газраас “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлж, хатуу хөл хорио тогтоох арга хэмжээ авбал ААН-ийн үйл ажиллагаанд “Маш их сөрөг нөлөө үзүүлнэ” гэж судалгаанд хамрагдсан ААН-ийн дийлэнх нь буюу 61.7 хувь нь хариулсан байна. Энэ нь өмнөх сарын судалгааны үр дүнгээс даруй 4.4 пунктээр өссөн байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО
ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР